



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2025 оны 12 сарын 24 өдөр

Дугаар А/808

Булган сум

Хариуцлагатай жижүүр томилох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.10 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Шинэ жилийн баярын өдөр буюу 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр аймгийн хэмжээнд цагийн нөхцөл байдлыг үнэлж, бүртгэн мэдээлэх, үүрэг бүхий хариуцлагатай жижүүрийг хавсралтад зааснаар томилсугай.

2.Хариуцлагатай жижүүрийн үүрэг гүйцэтгэх хугацаанд аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд гамшиг осол, хэрэг зөрчил, төв суурин газрын гэрэл цахилгаан, ус түгээлтийн хэвийн байдалд хяналт тавих, Онцгой байдлын газар, Цагдаагийн газар, Нэгдсэн эмнэлэг, Ус цаг уур, орчны шинжилгээний төв, “Булган Мээж” ОНӨХХК, “Эрдэнэт Булганы Цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК, “Мэдээлэл холбооны сүлжээ” ХХК-ийн Булган аймаг дахь салбар зэрэг байгууллагуудтай байнгын холбоотой ажиллах, Аймгийн Засаг даргын тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн даргатай тогтмол харилцах, цагийн байдлыг илтгэж ажиллахыг жижүүрийн үүрэг гүйцэтгэх албан тушаалтнуудад даалгасугай.

3.Хариуцлагатай жижүүрээр ажилласан тухай мэдээллийг нэгтгэн танилцуулахыг Аймгийн Засаг даргын тамгын газрын дарга (Д.Эрдэнэбилэг)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР



Аймгийн Засаг даргын 2025 оны  
12 дугаар сарын 24-ний өдрийн  
А/8.08 дугаар захирамжийн хавсралт

АЙМГИЙН ХАРИУЦЛАГАТАЙ ЖИЖҮҮРИЙН ХУВААРЬ

Д/д	Жижүүрийн нэр	Албан тушаал	Жижүүр хийх хуваарь	Харилцах утас
1	2	3	4	5
<b>2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр</b>				
1	Л.Нандинбат	Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч	09:00-11:30	90114105
2	Ц.Цолмонбаатар	Боловсролын газрын дарга	11:30-14:00	94474949
3	Н.Булган	Булган аймгийн Цахим шилжилт, үйлчилгээний хэлтсийн дарга	14:00-16:30	95793399
4	Х.Батхишиг	Биеийн тамир, спортын газрын дарга	16:30-19:00	80071646

Тайлбар:

- Хариуцлагатай жижүүр хийх хугацаандаа аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд нөхцөл байдалд хяналт тавьж Онцгой байдлын газар, Цагдаагийн газар, Нэгдсэн эмнэлэг, Ус цаг уур, орчны шинжилгээний төв, "Булган Мээж" ОНӨХХК, "Эрдэнэт Булганы Цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК, "Мэдээлэл холбооны сүлжээ" ХХК-ийн Булган аймаг дахь салбарын жижүүртэй холбоо барьж, жижүүрийн дэвтэрт тэмдэглэл хөтөлнө.